



**“ГЕРМЕС ЦЕНТР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ НЭЭЛТТЭЙ
БОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

1. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь компаниас хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг ил тод, үнэн зөв хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Үнэт цаас гаргагч нь нийтэд хагас жил, бүтэн жилийн эцсийн байдлаар компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг өөрийн компанийн цахим хуудас /hermescenter.mn/, Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.
- 1.3 Үнэт цаас гаргагч нь компанийн нийтэд хүргэх аливаа мэдээллийг Монгол хэлээр хүргэнэ.
- 1.4 Мэдээллийг үнэн зөв нийтэд хүртээмжтэй хүргэх ба энэ үйл ажиллагаанд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хяналт тавьж ажиллана.
- 1.5 Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 505 тоот тогтоолоор Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд хүргэх тухай журам"-ыг мөрдлөг болгож ажиллана.

2. Тайланг нийтэд мэдээлэх

- 2.1 Компани нь хагас жилийн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор, компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 02-ны өдрийн дотор өөрийн компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.
- 2.2 Компанийн үйл ажиллагааны тайланд дараах мэдээллүүдийг агуулсан байна.
 - 2.2.1 Компанийн зорилго, стратеги, тэдгээрийн хэрэгжилт
 - 2.2.2 Компани нь ижил төрлийн бизнесийн салбарт эзэлж буй байр суурь
 - 2.2.3 Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагын талаарх мэдээлэл
 - 2.2.4 Компанийн хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан, дүн шинжилгээ
 - 2.2.5 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай мэдээлэл
 - 2.2.6 Удирдлагын бүтцэд өөрчлөлт орсон тухай шийдвэр
 - 2.2.7 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр
 - 2.2.8 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн тухай мэдээлэл
- 2.3 Компани нь жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг тодруулгын хамт 2 дугаар сарын 20-ны өдрийн дотор өөрийн компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд тавина.
- 2.4 Компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлын зар болон ногдол ашгийн бодлого, хуваарилсан ногдол ашгийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тавина.

3. Мэдээллийг тухай бүр мэдээлэх, тавигдах хязгаарлалт



- 3.1 Компани нь хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад өөрийн компанийн санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлт, өмч хөрөнгийн болон удирдлагын бүтэц, зохион байгуулалттай холбоотой мэдээллийг тухай бүр мэдээлнэ.
- 3.2 Мэдээллийг Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон компанийн мэдээллийг хариуцсан ажилтан хийж гүйцэтгэнэ.
- 3.3 Мэдээллийн ажилтан нь нийтэд мэдээлсэн мэдээллийн архивыг бүрдүүлж, тэдгээрийг бүрэн бүтэн байдлаар хадгална.
- 3.4 Компанийн мэдээлэл хариуцсан ажилтан дотоод мэдээллийг нийтэд ил болгохоос өмнө санаатай болон санамсаргүй байдлаар бусдад мэдээлэх, дамжуулах, ашиглах нөхцлийг бүрэн хориглоно.
- 3.5 Компанийн мэдээлэл хариуцсан ажилтан нь бусдад хуурамч, бүрэн бус, төөрөгдүүлсэн байдлаар мэдээлэхийг хориглоно.

4. Хариуцлага

- 4.1 Компанийн мэдээлэл хариуцсан ажилтан нь энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд байгууллагын дотоод журмын дагуу хариуцлага хүлээнэ.